

ᠳᠤᠨᠳᠦᠭᠣᠪᠤ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2021

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны үр дүнгийн үзүүлэлт

Бүлэг 1

Удирдлага зохион байгуулалт

Бүлэг 2

Санхүүгийн тайлангийн аудит

Бүлэг 3

Гүйцэтгэлийн аудит

Бүлэг 4

Нийцлийн аудит

Бүлэг 5

ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачилгаар хийсэн аудит

Бүлэг 6

Дотоод ажил

Бүлэг 7

Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

Бүлэг 8

Дүгнэлт, санал

Хавсралт

1. Байгууллагын 2020 оны аудитын дүгнэлт
2. Төрийн аудитын газрын сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлт

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1

**УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ**

АЛСЫН ХАРАА

Монгол Улсын
хөгжлийн бодлого,
зорилтуудыг
хэрэгжүүлэхэд
чиглэсэн эдийн засаг,
нийгмийн өндөр үр
нөлөөтэй төрийн
аудитыг гүйцэтгэж,
арга зүй технологи,
үйл ажиллагаагаар
бүс нутгийн хэмжээнд
тэргүүлэх аудитын
дээд байгууллага
болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Төрийн санхүү, төсвийн
хяналтыг хараат бусаар
хэрэгжүүлж, харилцагч
талуудын хамтын
ажиллагааг сайжруулах
замаар иргэдийн
амьдралыг сайжруулна



**PROVINCE
AUDIT OFFICE**

ЭРХЭМХ ТӨСӨН ЗӨРЧЛӨЛ

Төрийн аудитыг
хэрэгжүүлэхдээ
хууль дээдлэх,
шударга ёсыг хангах,
ил тод, бодитой байх,
хараат бус, бие
даасан байх,
мэргэшсэн байх,
мэдээллээр бүрэн
хангагдах, төрийн
аудитын нийтээр
хүлээн зөвшөөрсөн
зарчим, стандартад
нийцэх зарчмуудыг
баримтална.

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



“Аудитыг цахимжуулан нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх жил”

1.1 Дэвшүүлсэн зорилтын биелэлт

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/76-1 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2019-2024 онд хэрэгжүүлэх “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар явуулах эрхзүйн болоод аргазүй технологийн таатай орчныг бүрдүүлнэ.” гэсэн стратеги зорилгын хүрээнд 6 зорилт дэвшүүлсэн бодлогын баримт бичгийг баталсан.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ



Стратеги зорилгын хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/09 дугаар тушаалаар 2021 оныг “Аудитыг цахимжуулан нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” жил болгон зарласан.

Төрийн аудитын газар нь 2021 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, шинэтгэлийг орон нутагт сурталчлан ажиллаж байна.

Тайлант онд харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих, аудитын чанар, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

1.1.1 Аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд 2019-2021 онуудад аймгийн Прокурорын байгууллага, Ерөнхий прокурортой хамтран ажиллаж байна.



Төрийн аудитын байгууллагаас санаачлан аймгийн Прокурорын байгууллага, Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөл, Санхүүгийн хяналт, аудитын албатай хамтран албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учруулсан хохирлыг барагдуулах ажлыг Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх хүрээнд хамтран ажиллаж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 2015 оноос хойш үүссэн эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлын судалгааг нэгтгэж, 22 иргэнтэй холбогдох асуудлыг Прокурорын газарт хүргүүлээд байна. Үүнээс Иргэний хуулийн 498.5 дахь хэсэгт зааснаар тухайн төрийн байгууллагаас нэхэмжлэл гаргах 15 иргэн, Захиргааны ерөнхий хуулийн 103.2-г зааснаар дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцан барагдуулах 7 иргэний асуудал байгаа юм.

1.1.2 Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн актын үлдэгдлийг барагдуулахаар Прокурорын тухай хуулийн 20-р зүйлд зааснаар аймгийн Прокурорын газар Шүүхэд нэхэмжлэл гаргаж, амжилттай шийдвэрлүүлээд байна.

Үүний үр дүнд Сум хөгжүүлэх сангийн 2008 оноос хойш төлөгдөөгүй хугацаа хэтэрч алданги тооцогдсон 1,289.6 /нэг тэрбум хоёр зуун наян есөн сая зургаан зуун мянга/ сая төгрөгийн актыг барагдуулах чиглэлээр аймгийн Прокурорын байгууллага, аймаг, сумдын Засаг дарга нартай хамтран ажилласнаар 1,051.1 /нэг тэр бум тавин нэгэн сая нэг зуун мянга/ сая төгрөгийн өрийг барагдуулж, 82 хувийн хэрэгжилттэй байна.

2017 онд Сум хөгжүүлэх сангийн 326 зээлдэгч эрсдэлтэй байсан бол 2018 онд 98, 2019 онд 20, 2020 онд 39 болж буурсан нь Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдэл буурч, зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж хэвшиж байгааг илтгэж байна. Мөн 2018 онд 85 зээлдэгчид 735.4 сая төгрөгийн зээлийг шинээр олгосон бол 2019 онд 129 зээлдэгчид 1,680.1 сая төгрөг, 2020 онд 104 зээлдэгчид 1,346.9 сая төгрөгийн зээлийг олгосон нь сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эргэлт сайжирч байгааг харуулж байна.

1.2 Бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаар тушаалаар төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан.

/Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаар тушаалын 3 дугаар хавсралт/



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь 12 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсан бөгөөд эхний хагас жилд 1 орон тоо дутуу буюу дарга, тэргүүлэх аудиторын үүргийг аудитын менежер түр орлон гүйцэтгэлээ.


Аудитын 1-р нэгжид 5, Аудитын 2-р нэгжид 2, Аудитын 3-р нэгжид 2 хүний бүрэлдэхүүнтэй, аудитын менежер аудитын 3 нэгжийн үйл ажиллагааг хянан удирдахаар зохион байгуулагдсан. Мөн дэмжих үйлчилгээний нэгжид нягтлан бодогч, дотоод ажил хариуцсан ажилтан, нярав жолооч ажиллаж, нийт 12 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Ажилтнууд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан, улирал бүр үйл ажиллагааны үр дүнгээ тайлагнаж байна. Харин нягтлан бодогч, дотоод ажил хариуцсан ажилтан, нярав-жолоочтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Төрийн аудитын газрын ажилтнуудын 11 нь нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, бүгд Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй.

1.3 Аудитын статистик үзүүлэлт

Төрийн аудитын газар 2021 онд **210** төсөв захирагчийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн **5**, өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн **2** аудит хийхээр төлөвлөсөн.




Санхүүгийн тайлангийн аудитад **207** байгууллага хамрагдаж, 2021 оны эхний хагас жилийн байдлаар бүх шатны төсөв захирагч нарын 2020 оны санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажууллаа.

Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх гүйцэтгэлийн **1** аудит, өмнөх оноос он дамжиж хийгдсэн нийцлийн **1** аудитыг дуусгахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасныг бүрэн хэрэгжүүлээд байна. Мөн өөрийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэх **2** гүйцэтгэлийн аудитын тайлагналын үе шатны ажлыг хэрэгжүүлж байна.

Гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн тайлангийн аудитаар нийт **2,460.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 86 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь өмнөх онд он дамжин хийгдсэн нийцлийн аудитын үр дүнгээс шалтгаалжээ. /Хавсралт №2/

Үүнээс санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил өмнөх оны мөн үеэс 82 хувиар буурсан нь аймаг, сумдын Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, орон нутгийн төсвийн байгууллагууд Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад чиглэсэн ажлуудыг зохион байгуулж ажилласны үр дүн юм.




Тайлант хугацаанд хохирлыг нөхөн төлүүлэх **165.6** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос **17.4** сая төгрөг төвлөрч, **142.5** сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулах хугацаа болоогүй байна. Ингэснээр төлбөрийн актын хэрэгжилт 75 хувьтай байна. Орон нутгийн төсвийн орлогод 9.8 сая төгрөгийг,

тухайн байгууллагын дансанд 7.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.



Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар нийт 1,431.7 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага өгсний 738.6 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжиж, 555.9 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна. Ингэснээр албан

шаардлагын хэрэгжилт 84.3 хувьтай байна.



Тайлант онд 37 заалт бүхий зөвлөмжийг харилцагч байгууллагад хүргүүлснээс 10 заалт зөвлөмж хэрэгжиж, 9 заалт зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй бөгөөд хэрэгжилт 35.7 хувь байна.

Аудитын явцад залруулах боломжтой 836.1 сая төгрөгийн алдааг залруулсан нь өмнөх онтой харьцуулахад 91 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд аудитын үр дүнгээс 52.5 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд нэг төгрөгт ногдох үр өгөөж 0.3 төгрөг байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015



ЭНДЭГХИЙН ТАМГА ТАМГА
ТАМГА ТАМГА ТАМГА

ЭНДЭГХИЙН ТАМГА

ЭНДЭГХИЙН ТАМГА

ЭНДЭГХИЙН ТАМГА



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮН

2.1 “Төсөв захирагч нарын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит”

Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулиар тодорхойлсон чиг үүргийнхээ дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн нийт **210** санхүүгийн тайланд аудит хийхээр төлөвлөснөөс **207** санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас 78 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 114 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар батлагдсан журмын дагуу шалгуур хангасан 15 байгууллагад итгэл үзүүлж, 3 байгууллагад харилцагч байгууллагаас шалтгаалан аудит хийгдээгүй болно. 2021 дараах 3 байгууллагад аудит хийгээгүй. Үүнд:


1. Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2020 оны 8 дугаар сарын 01-ний өдөр татан буугдсан тул аудит хийгдээгүй.
2. Баянжаргалан сумын ЭЭС-ийн нягтлан бодогч аудитад саад учруулж, санхүүгийн тайланг аудитад ирүүлээгүй тул аудит хийлгүй, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.
3. Дэрэн сумын Эрдэм шинжилгээ, туршилт үйлчилгээ ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулаагүй тул аудит хийгээгүй.




Нийт 78 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаснаас 71 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 6 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлтийг гаргалаа.

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ


Зөрчилгүй санал дүгнэлт



Хязгаарлалттай



- Цагаандэлгэр сумын ЗДТГ
- Өндөршил сумын ЗДТГ
- Хулд сумын ЭМТ
- Сайхан-Овоо сумын ЗД
- Хулд сумын ЗД
- Гурвансайхан сумын ЗД



Аймгийн ЗДТГ

Сөрөг

“Сөрөг” дүгнэлт авсан *Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын* дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд тус тус хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,937.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залруулж болох 836.1 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 909.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг нөхөн төлүүлэхээр 165.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 26.7 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар
1,937.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Төлбөрийн акт



Албан шаардлага



Зөвлөмж



Залруулга

Тайлант онд аудитаар илэрсэн алдаа, зөрчил өмнөх оны мөн үеэс 8,627.2 сая төгрөгөөр буурсан нь залруулсан алдааны бууралтаас шалтгаалсан байна.

Алдаа, зөрчлийг агуулгаар нь ангилбал нягтлан бодох бүртгэлийн алдаа нийт алдаа, зөрчлийн 62 хувийг эзэлж байгаа бөгөөд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөрчил буюу залруулсан алдаа өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа ч аудитаар илэрсэн зөрчлийн дийлэнх хувийг эзэлсээр байна.

Мөн энэ тайлант хугацаанд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчил, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 45.8 хувийг эзэлж байгаа нь төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлд тавих хяналт сул, төсөв захирагч нарын хууль эрхзүйн мэдлэг хангалтгүй байгаатай холбоотой байна.

/Сая төгрөг/



2.2 “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит”



тэр бум төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 2 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын газар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан, “Зөрчилгүй” санал дүгнэлтийг хуулийн хугацаанд аймгийн Засаг даргад гардуулж, аудитын тайланд дурдсан зөвлөмжүүдийг танилцуулав.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1.4

Тус аудитаар төсөв захирагч нарын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, төсвийн ил тод байдлыг хангах, ЭЭС-ийн асуудлыг шийдвэрлэх талаар 3 заалт бүхий зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүллээ.

ЗӨВЛӨМЖ



Төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрч буй зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, гарсан зөрчлийг арилгах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг тайлант хугацааны явцад хийж, жилийн эцсийн тайлан гарахаас өмнө хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах



Эм эргэлтийн сангийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналтыг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, цаашид тус сангийн бүтэц зохион байгуулалтыг судалж, оновчтой хэлбэрээр шийдвэрлэх




Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажил зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд хийх аудитыг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гүйцэтгэж, аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүллээ.

Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг жил бүрээр харьцуулан, мэдээллийн сан бүрдүүлж, дүн шинжилгээ хийсэн нь энэ аудитын онцлог байв.

Тус аудитаар орлогыг судалгаа, шинжилгээ хийлгүй, өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан бодитой бус төлөвлөсөн, төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил өмнөх оноос 19.0 хувиар буурсан ч төсвийн хөрөнгийг үрэлгэн, хууль, тогтоомж зөрчин зарцуулсан зөрчлүүд илэрсээр байгаа нийтлэг зөрчил байлаа.



Аудитаар нийтлэг илэрсэн зөрчлийг арилгах, орон нутгийн төсвийн үр ашгийг сайжруулах чиглэлээр төсвийн ерөнхийлөн захирагчид 4 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив" нь 21 жилийн өмнө батлагдсан, тухайн үеэс бараа, ажил үйлчилгээ үнэ хөлс нэмэгдсэн зэргээс шалтгаалан уг тогтоолыг мөрдөж ажиллахад хүндрэл үүсэж, зөрчил давтагдан гарсаар байгаа тул *"Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын нормативыг цаг үе, эдийн засгийн нөхцөл байдал, бараа, ажил үйлчилгээний үнийн өөрчлөлт зэрэгт нийцүүлэн тогтоох"* гэсэн зөвлөмжийг хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газарт уламжлав.

Санхүүгийн тайлангийн аудитаар 49.2 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож, хүлээн зөвшөөрүүлээ.

"Аудитад зарцуулсан өдөр 775, илүү цаг 430"



ᠮᠤᠩᠭᠡᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ

3

ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТ

3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

2021 оны эхний хагас жилд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар 1 аудит гүйцэтгэхээр төлөвлөснийг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж, аудитын тайланг шалгагдагч байгууллага болон Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 522.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 522.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх 9 заалт бүхий зөвлөмж өглөө.




3.1 “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”

Гүйцэтгэлийн аудитын дүн, нотлох баримтад үндэслэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлт үр дүн муутай байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Нийт төсөл арга хэмжээний 61% нь аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдаагүй, барилгын ажлын зураг төслийг боловсруулахдаа бодит хэмжилт, тооцоо судалгаа хийгээгүй, ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг тусгаагүй, ТАХ-ний байршлыг аймгийн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй этгээдтэй гэрээ байгуулсан зэрэг нийт 14 нэр төрлийн зөрчил илэрч, 412.3 сая төгрөгийн 7 нэр төрлийн зөрчилд хугацаатай албан шаардлага, 7 нэр төрлийн зөрчилд зөвлөмж өгч, холбогдох албан тушаалтанд аудитын дүнг, зөрчлийн нэгтгэлийн хамт хүргүүлсэн.

Аудитын явцад аймагт хийгдсэн хөрөнгө оруулалтууд иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, сургууль, цэцэрлэгүүдийн хүчин чадлын хэтрэлтийн судалгаа, ТАХ-ний зураг төсөлд харьцуулсан судалгаа хийсэн зэрэг нь энэ жилийн аудитын онцлог байсан.




Цэцэрлэг: 2020 онд аймгийн хэмжээнд төрийн өмчийн 3 цэцэрлэг нь хүчин чадлын хэмжээнд хүүхэд элсүүлсэн, үлдсэн 19 цэцэрлэг нь хүчин чадлаас 10-50%-иар илүү хүүхэд элссэн буюу ачаалал хэтрэлттэй байна.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 8 цэцэрлэг 1025 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай боловч цэцэрлэгт нийт 1412 хүүхэд хамрагдаж, ачаалал хэтрэлт 38% байгаа нь бусад цэцэрлэгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байна.

Сургууль: Аймгийн хэмжээнд 6-18 хүртэлх насны нийт 10451 хүүхэд байна. 2020-2021 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй 19 төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын барилгын нийт суурилагдсан хүчин чадал 8544 хүүхэд хүлээн авах боломжтойгоос 8496 хүүхэд хүлээн авч аймгийн хэмжээнд сургуулийн барилгын нийт хүчин чадлын ашиглалт 99%-тай байна.

Сургуулийн хүчин чадал ашиглалт



Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн ачаалал хэтрэлт хамгийн өндөр буюу 105%, ЭДЦС 60%, Хүмүүнлэг 49%, Эрдэнэдалай сумын ахлах сургууль 25%-ийн хүчин чадлын хэтрэлттэй ажиллаж байгаа бол Өлзийт сумын дунд сургуулийн хүчин чадлын ашиглалт - 50% буюу ашиглагдаагүй хүчин чадал хамгийн өндөр үзүүлэлттэй, Хулд, Луус, Говь-Угтаал, Өндөршил сумын сургуулиудын ашиглагдаагүй хүчин чадал 33-47% байна.

Иймд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо барилгын насжилт, чанар, хүртээмж, хүн ам, нийгэм эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулж төлөвлөх шаардлагатай байна.



тооцох арга хэмжээ аваагүй зэрэг нийт 6 зөрчил илрүүлж 4 зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өгч, зөрчлийн жагсаалтыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.



Мөн тус аудитын хүрээнд “*Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн*”-д гүйцэтгэлийн аудит хийж тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй хувь хүнтэй шууд гэрээ байгуулсан, техникийн тодорхойлолтод зааснаас зөрүүтэй бараа, үйлчилгээг нийлүүлсэн, гэрээний үүргээ биелүүлээгүй компанид хариуцлага

“Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын Land Cruiser 200 маркийн автомашины парк засвар”-ын ажилтай холбоотой асуудлыг ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй гэж үзэн Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д зааснаар прокурорын байгууллагад мэдэгдэн эрүүгийн хэрэг үүсгүүлэх албан хүсэлтийг Ерөнхий аудиторт хүргүүллээ.



4

НИЙЦЛИЙН АУДИТ



4. НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

4.1 2020 оноос он дамжин хэрэгжсэн “Нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган нийтэд мэдээлэх” ажил



Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу аймаг, сумын орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн 3 нам, 626 нэр дэвшигчид зардлын тайлангаа ирүүлснийг хянав. Үүнээс 447 нэр дэвшигч Х тайлан өгсөн бөгөөд аймаг, сумын 30 намын хорооны болон 179 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулах аудитын ажлыг гүйцэтгэж, тайланг олон нийтэд мэдээлсэн.

Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан

Орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн 2 намын 15 намын хороонд 1 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 25 иргэний, 2 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 4 аж ахуй нэгжийн мэдээллийг олон нийтэд мэдээлсэн.

Намууд 87.3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, 83.4 сая төгрөгийг орон нутгийн сонгуульд зарцуулжээ.

ААНБ-ын хандив
29.0 сая төгрөг



Намын өөрийн хөрөнгө
14.4 сая төгрөг

Иргэдийн хандив
43.9 сая төгрөг

Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

Орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн 12 нэр дэвшигчид 1 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 23 иргэний мэдээллийг гаргаж олон нийтэд мэдээлсэн.

Нэр дэвшигчид 132.6 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, 130.7 сая төгрөгийг орон нутгийн сонгуульд зарцуулжээ.

ААНБ-ын хандив
1.0 сая төгрөг




Нам болон нэр дэвшигчийн
хөрөнгө
54.0 сая төгрөг

Иргэдийн хандив
77.6 сая төгрөг



5
ӨӨРИЙН
САНААЧИЛГААР
ХИЙСЭН АУДИТ



6 ДОТООД АЖИЛ

ТӨРИЙН
АУДИТ

ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ

6. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1 Хүний нөөц

Төрийн аудитын газар нь 2021 онд ажилтнуудын багаар ажиллах, дүн шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарал хандуулан ажиллахаар төлөвлөөд байна.

Тэргүүлэх аудитор “ТАБ-ын Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 9 ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллаж байна.



2021 оны 2-р улиралд гүйцэтгэлийн тайлангийн гүйцэтгэлийн зорилт хэсгийг 7 үзүүлэлтээр 8 ажилтны гүйцэтгэлийн тайланг үнэлснээс 4 ажилтан "Бүрэн хангалттай", 4 ажилтан "Хангалттай" үнэлгээ авсан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, ажилтан бүртэй байгууллагын соёл төлөвшүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулан, ажилтнуудын давуу тал, сул талыг ярилцаж, 2021 оны “Сургалт, хөгжлийн төлөвлөгөө”-нд саналыг тусгасан нь ажилтнуудад урам өгсөн ажил боллоо.

Төрийн аудитын байгууллагын “Нийгмийн хамгааллын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын газрын хэмжээнд боломжит ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 10 ажилтанд сургалтын хөнгөлөлтөд 900.0 мянган төгрөг, 1 ажилтанд дотоод журмын дагуу 737.8 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгоод байна.

Монгол Улсын Үндэсний их сургуультай хамтран ажилтнуудыг эрхзүйч мэргэжлээр суралцуулах, элсэлтийг Дундговь аймагт зохион байгуулан, Төрийн аудитын газрын 9 ажилтан эрхзүйч мэргэжлээр суралцаж байна.

6.2 Мэргэжлийн тасралтгүй сургалт

Төрийн аудитын байгууллагын 2021 оны зорилт, Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр ажилтнуудын сургалтын хэрэгцээнд тулгуурлан 2021 оны 3-р сараас 11 сар хүртэл хэрэгжүүлэхээр “Сургалт, хөгжлийн төлөвлөгөө”-г баталлаа.

Ажилтнуудыг идэвхжүүлэн багуудад хуваарилан ажил сайжруулах чиглэлээр 8 ажил, ажилтнуудын илтгэх чадварыг сайжруулах, хувь хүний хөгжилд чиглэсэн 7 сургалтын сэдвийг агуулснаараа энэ жилийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөний онцлог юм.

Сургалт, хөгжлийн төлөвлөгөөний дагуу 3 сургалт /"Ажлын бүтээмж /Ажилтнуудын давуу болон сул талыг тодорхойлсон захидал/", "Монгол бичиг", "Англи хэл" сургалт/, 2 багийн ажил /"Гэр бүлийн талархлын өдөрлөг зохион байгуулах", "Нийтээр мод тарих аянд оролцох"/ зохион байгуулаад байна.

"Ажлын бүтээмж" сэдвээр зохион байгуулсан сургалт нь байгууллагын болон ажилтны бүтээмжид юу юу нөлөөлдөг, гүйцэтгэл болон бүтээмжийн ялгаа, монгол хүний бүтээмж




Ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Ч.Оюунтүлхүүр, Л.Уранбилэг нар “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээний сургалт”, ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Л.Уранбилэг нар “Хуулийн хэрэглээ” сургалтад хамрагдаж, шалгалтаа амжилттай өглөө.

хэр түвшинд үнэлэгддэг талаар сонирхолтой мэдээлэл өгсөн сургалт боллоо.

Мөн ажилтнуудаас байгууллагын соёлын судалгаа авч, аудитын менежерийн зүгээс ажилтан бүрд захидал бичиж хүргүүлэн, ажилтнуудын давуу талаа боломж болгон ашиглах, сул талаа засаж давуу тал болгон хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулав.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олон аймгаас хэрэгжүүлж буй "8 ТҮМЭН МОД ТАРИХ" хөдөлгөөнд нэгдэж, улсын чанартай зам дагуу 60 мод тарьж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг арга хэмжээнд хувь нэмэр орууллаа.



6.3 Мэдээллийн ил тод байдал



6.3.1 Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан”, “ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан”, төрийн аудитын үйл ажиллагаатай холбоотой 12 мэдээллийг цахим хуудас болон Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар facebook хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэв.



6.3.2 Сумдын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнг танилцуулж, Шилэн дансны цахим хуудсанд хууль, журамд заасан хугацаанд мэдээллийг үнэн зөв байршуулах, Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй иргэдийн саналаар дэмжигдээгүй, зураг төсөвгүй, зориулалт бус ТАХ-г төлөвлөж санхүүжүүлэхгүй

6.5 Төрийн болон албаны нууцтай холбоотой үйл ажиллагаа



Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, Төрийн аудитын байгууллагын төрийн болон албаны нууц хамгаалах дотоод журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хийх жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулав.

Төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөөний дагуу бүх ажилтнуудын нууцын баталгааг шинэчилж баримтжуулан, нууцын албан хэрэг хөтлөлтийн 10 дэвтрийг хөтөлж, ажилтнуудын нууцын баталгааг шинэчлэн баримтжуулсан.

Эхний хагас жилд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 онд хэрэгжүүлсэн төрийн болон албаны нууц хадгалах, хамгаалах ажлын тайланг УАГ, Дундговь аймаг дахь Тагнуулын хэлтэст хүргүүллээ.

6.6 Архив, албан хэрэг хөтлөлт



Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, зааварт нийцүүлэн ажиллаж байна.

6.6.1 Төрийн аудитын газарт 2-р улиралд 397 албан бичиг ирж, харилцагч байгууллагад 286 албан бичгийг хүргүүлэн, 15 тушаалыг баталгаажуулав.

6.6.2 Аудитаар шалгадагч байгууллагуудад тогтоосон 51 төлбөрийн акт, зөрчил арилгах 160 албан

шаардлагыг хэвлэж, дугаарлаж хүргүүлсэн. Санхүүгийн тайлангийн аудитын үеэр 78 аудитын дүгнэлт буюу гэрчилгээг хэвлэсэн байна.

6.6.3 Архивын хууль тогтоомжийн дагуу баримт хадгаламжийн нэгжийг заасан хугацаанд ажилтнуудаас хүлээн авч, архивлах ажлыг хэрэгжүүлж, 136 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, бүртгэл хөтлөөд байна.

6.6.4 2021 оны 2-р улирлын байдлаар Төрийн аудитын газарт 6 өргөдөл ирүүлснийг өргөдөл, гомдлын бүртгэлд бүртгэж, хуулийн хугацаанд хариуг хүргүүллээ. Өргөдөл гомдол ирүүлсэн иргэн, өргөдлийн агуулга, өргөдөл ирүүлсэн хугацаа, хариу хүргүүлсэн хугацаа, хариу хүргүүлсэн албан бичгийн дугаар зэрэг мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтөлж, өргөдөл, гомдлын бүртгэл, тайланг баримтжуулж ажиллаж байна.

7

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

МОНГОЛЫН
ЭРХНИЙН
ХАМГААГАХ
ЗӨЛӨӨСӨЛ



7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

7.1 Санхүүгийн үйл ажиллагаа



7.7.1 2020 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлэн гаргаж “Мишээл Од” аудитын компанид шалгуулж “Зөрчилгүй санал дүгнэлт” авч ажиллалаа.

7.7.2 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 230,010.4 мянган төгрөгийн санхүүжилт орсноос эдийн засгийн ангиллын дагуу 192,493.8 мянган төгрөгийг зарцуулж, 37,516.5 мянган төгрөгийн

үлдэгдэлтэй байна.

Нийгмийн даатгалын хэлтэстэй сар бүр тооцоо нийлж нийт өссөн дүнгээр 34,693.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 10,806.4 мянган төгрөгийг татварт төлжээ.

/Мянган төгрөг/

Төрийн аудитын газрын 2021 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл

Нэр	Батлагдсан төсөв	Зарцуулах эрх	Гүйцэтгэл	Үлдэгдэл
Төсвөөс санхүүжих	234,464.4	230,010.4	192,493.8	37,516.6
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	196,815.2	194,015.2	165,984.3	28,030.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,052.0	25,052.0	21,995.5	3,056.5
Хангамж, бараа материалын зардал	5,245.0	4,097.6	1,310.2	2,787.4
Томилолт, зочны зардал	3,850.2	3,573.6	1,200.0	2,373.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,702.0	1,572.0	360.1	1,211.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.0	900.0	900.0	-
Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшуулал	800.0	800.0	743.8	56.3

7.2 Шилэн дансны мэдээлэл

№	Тайлангийн нэр	2018 1-р хүрээ	2019 1-р хүрээ	2020 1-р хүрээ	2021 1-р хүрээ	2021 2-р хүрээ	2021 3-р хүрээ	2021 4-р хүрээ
1	Дотоод төсвийн төсвийн төсөв (Бүтэц)							
2	Төсвийн байгууллагын байгууллагын төсөв, үйлчилгээ, өмчийн хөрөнгийн хөрөнгийн төсөв (Бүтэц)							
3	Төрийн өмчийн төсвийн төсөв, өмчийн (Бүтэц)							
4	Өмчийн төсвийн төсвийн төсөв, өмчийн (Бүтэц)							
5	Төрийн өмчийн төсвийн төсөв, өмчийн (Бүтэц)							
6	Өмчийн төсвийн төсөв, өмчийн (Бүтэц)							

Төрийн аудитын газар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2021 оны батлагдсан төсвийг бүтэн жил хэсэгт цаг хугацаанд нь цахимаар болон самбараар мэдээлсэн.

Сар бүр, тухай бүр мэдээлэх мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээг цаг хугацаанд нь цахимаар болон самбараар мэдээллээ.

Өмч хөрөнгө, өр авлага үүсгэсэн, мөнгө зарцуулсан аливаа шийдвэр хэсэгт 1,557.8 мянган төгрөгийн 3 тушаалыг мэдээлж, 1-р улирлын шилэн дансны тайланг илгээгээд байна.

8.1 ДҮГНЭЛТ

Манай хамт олон байгууллагын 2021 оны үйл ажиллагаагаа төрийн аудитын байгууллагын стратеги, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 онд дэвшүүлсэн зорилтод чиглүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, үр дүнг тооцон ажиллаж байна.

2021 онд ажилтнуудын хувийн хөгжил болон багаар ажиллах, дүн шинжилгээ хийх ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарал хандуулан аудитын чанарыг сайжруулахаар зорьсон нь энэ жилийн томоохон зорилтын нэг юм. Энэ ажлын хүрээнд ажилтнуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан Сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Мөн 2020 онд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд түгээх ажлыг тал бүрээр санаачлан хэрэгжүүлж ажилласны үр дүнд 2021 оны хагас жилийн байдлаар байгууллагын цахим хуудасны хандалтын тоо 2 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь бидний ажлын ололт билээ.

БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ АУДИТЫН ДҮГНЭЛТ

**МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК**Нягтлан бодох бүртгэл- Аудит, Баталгаажуулалт,
Аутсорсингийн үйлчилгээ, Бизнесийн зөвлөгөө өгөхДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Х.НАРАНЦАЦРАЛ ТАНАА

__2021.04.02__ № __A/50__

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9. 1-д заасны дагуу Дундговь аймаг дахь төрийн аудитын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймаг дахь төрийн аудитын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Дундговь аймаг дахь төрийн аудитын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МИШЭЭЛ ОД АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ



2021 оны 04 дугаар сарын 02-ны өдөр



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

/сая төгрөг/

Үзүүлэлт		Он				
		2016	2017	2018	2019	2020
Хийгдсэн аудитын тоо		167	258	220	222	226
Санхүүгийн аудит		148	246	209	211	212
Гүйцэтгэлийн аудит		5	7	6	6	7
Нийцлийн аудит		7	5	5	5	7
Бусад аудит		7				
Хамрагдсан байгууллага		393	246	699	503	683
Үр өгөөж	Бүртгэсэн	33,685.6	20,197.6	1468.2	952.6	
	Тооцсон	29,117.2	24,463.9	1,204.5	641.3	754.5
Төлбөрийн акт	Тогтоосон	31	37	64	68	85
		17.2	526.3	521.1	345.0	412.6
	Барагдуулсан	29	26	48.0	48.0	55.0
		12.4	64.7	260.8	142.1	44.3
Албан шаардлага	Өгсөн	234	116	171.0	323.0	380.0
		29,164.6	4,981.7	7,254.7	2,494.0	11,164.4
	Хэрэгжсэн	223	106	165.0	306.0	300.0
		28,583.1	4,832.5	2,408.1	2,419.6	10,616.0
Зөвлөмж	Өгсөн	136	222	111	87	70
	Хэрэгжсэн	84	191	74	66	51
Илрүүлсэн зөрчлийн дүн	Илрүүлсэн	39,111.3	25,224.7	19,454.4	11,207.2	20,441.9
	Залруулсан	7,201.2	2,760.6	9613.1	8,215.5	9,395.3
Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал	Гаргасан	56	4	18	66	46
	Хэрэгжсэн	56	4	6	47	44
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	Шилжүүлсэн			4		3
	Хэрэгжсэн			4		1
Төсвийн орлого нэмэгдүүлэх санал		3	4	2	6	6
		132.6		57.8	339.7	325.5
Үүнээс: Хэрэгжсэн санал		9	9		3	4
		132.6			196.5	146.9
Батлагдсан орон тоо		11	11	11	12	12
Төсөв, санхүүжилт	Батлагдсан	197.8	205.6	194.4	280.3	477.4
	Гүйцэтгэл	197.5	204.8	185	233.6	399.9
1 төгрөгт ногдох үр өгөөж		147.4	119.5	6.5	2.7	1.9

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ᠐ᠨ